



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/68/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор аймаг 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mm</p> <p>Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mm</p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mm</p> <p>Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhndl@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Агуулга

2. Аудитын санал дүгнэлт /эх хувь/	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт	14
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Аудитын зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/63

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\2022-A4 тоот.docx

005020361

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>118,999,312.80</u>	<u>68,037,026.20</u>
33	АВЛАГА	19,950,000.00	61,825.72
335	Бусад авлага	19,950,000.00	61,825.72
3351	Байгууллагаас авах авлага	19,950,000.00	61,825.72
35	БАРАА МАТЕРИАЛ	99,049,312.80	67,975,200.48
351	Түүхий эд материал	92,100,312.80	62,158,200.48
35110	Тусгай зориулалттай материал	92,100,312.80	60,228,700.48
35130	Эм боох материал	-	1,929,500.00
354	Хангамжийн материал	6,949,000.00	5,817,000.00
35410	Бичиг хэргийн материал	978,000.00	-
35420	Аж ахуйн материал	1,932,000.00	1,778,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,039,000.00	4,039,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,117,418,620.85</u>	<u>1,046,538,302.64</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,117,418,620.85	1,046,538,302.64
392	Биет хөрөнгө	1,102,946,620.85	1,032,552,302.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,110,464,850.00	1,090,026,165.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(97,052,299.80)	(142,369,253.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,085,430.37	128,035,430.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,666,529.24)	(91,303,177.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,892,376.00	57,892,376.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,852,344.68)	(30,855,538.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,790,700.00	18,790,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,348,837.52)
39217	Ном	4,284,438.20	4,684,438.20
393	Биет бус хөрөнгө	14,472,000.00	13,986,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,472,000.00	13,986,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,236,417,933.65</u>	<u>1,114,575,328.84</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,236,417,933.65</u>	<u>1,114,575,328.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,236,417,933.65	1,114,575,328.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	147,876,387.30	147,876,387.30
51101	Өмч: - төрийн	147,876,387.30	147,876,387.30
512	Хуримтлагдсан үр дүн	442,011,613.05	340,943,566.97
51210	Өмнөх үеийн үр дүн	442,011,613.05	462,786,171.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	(121,842,604.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	646,529,933.30	625,755,374.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,236,417,933.65</u>	<u>1,114,575,328.84</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>764,980,995.85</u>	<u>581,231,476.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>123,943,295.85</u>	<u>1,429,240.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	123,943,295.85	1,429,240.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	123,943,295.85	1,429,240.00

Аудитын код **БНА-2022/68/НА-СТА-ТШЗ**

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	784,250.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	123,159,045.85	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	1,329,240.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,065,200.00	120,795,236.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	557,972,500.00	459,007,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,036,300.00	43,299,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,036,300.00	32,625,625.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	10,674,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,028,900.00	77,495,611.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,028,900.00	77,495,611.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	625,731,424.26	683,107,365.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,731,424.26	683,107,365.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	577,424,929.03	635,538,161.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,578,084.77	338,979,552.28
210101	Үндсэн цалин	359,578,084.77	338,979,552.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,778,382.00	43,008,067.98
210201	Тэтгэврийн даатгал	30,179,203.57	31,568,625.89
210202	Тэтгэмжийн даатгал	3,550,105.54	2,857,958.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,979,045.14	2,286,566.47
210204	Ажилгүйдлийн даатгал	706,060.56	571,691.58
210205	Эрүүл мэндийн даатгал	7,363,967.19	5,723,225.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,582,077.00	76,495,611.00
210301	Гэрэл, цахилгаан	3,318,457.00	1,922,721.00
210302	Түлш, халаалт	68,556,020.00	74,062,890.00
210303	Цэвэр, бохир ус	707,600.00	510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,385,900.00	41,507,812.32
210401	Бичиг хэрэг	1,465,100.00	1,782,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,880,000.00	1,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,000.00	1,261,700.00
210404	Ном, хэвлэл	471,900.00	124,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	110,000.00	1,240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,693,900.00	3,112,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	32,587,212.32
2105	Нормативт зардал	16,790,265.00	13,279,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,441,250.00	1,224,000.00
210502	Хоол, хүнс	15,349,015.00	11,502,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	553,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,814,188.00	2,168,100.00
210604	Урсгал засвар	3,814,188.00	2,168,100.00
2107	Томилот, зочны зардал	1,643,500.00	544,000.00
210702	Дотоод албан томилот	1,643,500.00	544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,053,700.00	44,385,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,603,700.00	43,645,325.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,798,832.26	75,170,442.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	509,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,488,050.00	2,577,600.00

Аудитын код **БНА-2022/68/НА-СТА-ТШЗ**



Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,801,782.26	72,592,842.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,306,495.23	47,569,204.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,955,700.00	25,854,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,500,500.00	12,135,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,036,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,418,900.00	13,718,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	446,823.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	446,823.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,903,972.23	21,714,704.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,903,972.23	21,714,704.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	139,249,571.59	(101,875,889.22)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	19,966,715.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	19,966,715.59
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(19,966,715.59)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	139,249,571.59	(121,842,604.81)


2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	641,821,950.00	579,802,236.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	126,250.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	126,250.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	126,250.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,250.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	641,695,700.00	579,802,236.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	557,972,500.00	459,007,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,694,300.00	43,299,625.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,036,300.00	32,625,625.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	658,000.00	10,674,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,028,900.00	77,495,611.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,028,900.00	77,495,611.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	594,089,442.00	579,402,236.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,089,442.00	579,402,236.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,782,946.77	531,833,031.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,578,084.77	338,979,552.28
210101	Үндсэн цалин	261,994,376.60	256,239,455.96
210102	Нэмэгдэл	50,209,583.34	59,366,576.00
210104	Урамшуулал	47,374,124.83	23,373,520.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,778,382.00	43,069,893.70
210201	Тэтгэврийн даатгал	29,620,300.00	31,630,451.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,824,900.00	2,857,958.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,985,643.00	2,286,566.47
210204	Ажилгүйдлийн даатгал	697,739.00	571,691.58
210205	Эрүүл мэндийн даатгал	7,649,800.00	5,723,225.99

Аудитын код **БНА-2022/68/НА-СТА-ТШЗ**



Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,582,077.00	76,495,611.00
210301	Гэрэл, цахилгаан	3,318,457.00	1,922,721.00
210302	Түлш, халаалт	68,556,020.00	74,062,890.00
210303	Цэвэр, бохир ус	707,600.00	510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,666,300.00	7,764,100.00
210401	Бичиг хэрэг	2,141,600.00	804,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,880,000.00	1,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,000.00	1,261,700.00
210404	Ном, хэвлэл	471,900.00	124,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	419,900.00	1,240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,987,900.00	2,934,000.00
2105	Нормативт зардал	18,118,165.00	15,848,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,316,350.00	3,222,500.00
210502	Хоол, хүнс	15,349,015.00	11,502,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,452,800.00	1,124,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,914,188.00	2,168,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,100,000.00	-
210604	Урсгал засвар	3,814,188.00	2,168,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,643,500.00	544,000.00
210702	Дотоод албан томилолт	1,643,500.00	544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,053,700.00	44,385,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,603,700.00	43,645,325.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,448,550.00	2,577,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	880,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,568,550.00	2,577,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,306,495.23	47,569,204.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,955,700.00	25,854,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,500,500.00	12,135,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,036,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,418,900.00	13,718,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	446,823.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	446,823.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,903,972.23	21,714,704.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,903,972.23	21,714,704.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	47,732,508.00	400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	47,732,508.00	400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,732,508.00	400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,732,508.00	400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,732,508.00	400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(47,732,508.00)	(400,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	302,762,041.46	1,097,168,362.06
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	139,249,571.59	139,249,571.59
C08	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	442,011,613.05	1,236,417,933.65
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	442,011,613.05	1,236,417,933.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	20,774,558.73	20,774,558.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	462,786,171.78	1,257,192,492.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-20,774,558.73	00.00	-20,774,558.73
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-121,842,604.81	-121,842,604.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	625,755,374.57	340,943,566.97	1,114,575,328.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31					/төгрөгөөр/
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	541,847,400.00	514,787,906.98	27,059,493.02	95.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,847,400.00	514,787,906.98	27,059,493.02	95.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	510,388,100.00	488,933,406.98	21,454,693.02	95.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,729,800.00	338,979,552.28	7,750,247.72	97.76
210101	Үндсэн цалин	262,093,500.00	256,239,455.96	5,854,044.04	97.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,128,600.00	43,069,893.70	1,058,706.30	97.60
210201	Тэтгэврийн даатгал	32,052,300.00	31,630,451.61	421,848.39	98.68
210202	Тэтгэмжийн даатгал	3,019,100.00	2,857,958.05	161,141.95	94.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,415,300.00	2,286,566.47	128,733.53	94.67
210204	Ажилгүйдлийн даатгал	603,800.00	571,691.58	32,108.42	94.68
210205	Эрүүл мэндийн даатгал	6,038,100.00	5,723,225.99	314,874.01	94.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,840,400.00	76,495,611.00	5,344,789.00	93.47
210301	Гэрэл, цахилгаан	3,569,000.00	1,922,721.00	1,646,279.00	53.87
210302	Түлш, халаалт	77,761,400.00	74,062,890.00	3,698,510.00	95.24
2104	Хангамж, бараа материалын зардал	8,407,900.00	8,164,100.00	243,800.00	97.10
210401	Бичиг хэрэг	804,000.00	804,000.00	-	100.00

Аудитын код **БНА-2022/68/НА-СТА-ТШЗ**



Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	1,400,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,621,200.00	1,261,700.00	359,500.00	77.83
210404	Ном, хэвлэл	534,200.00	524,400.00	9,800.00	98.17
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,240,000.00	1,240,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	22,906,000.00	15,848,850.00	7,057,150.00	69.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,222,500.00	3,222,500.00	-	100.00
210502	Хоол, хүнс	18,433,900.00	11,502,250.00	6,931,650.00	62.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,249,600.00	1,124,100.00	125,500.00	89.96
210604	Урсгал засвар	2,168,100.00	2,168,100.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,085,700.00	1,085,700.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	345,700.00	345,700.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	541,847,400.00	514,787,906.98	27,059,493.02	95.01
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,840,400.00	77,495,611.00	5,344,789.00	93.55
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	-	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	293.00	293.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31			/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,694,300.00	43,299,625.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,694,300.00	43,299,625.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	658,000.00	10,791,295.00	
210401	Бичиг хэрэг		117,295.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	658,000.00	10,674,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	658,000.00	10,674,000.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,036,300.00	32,508,330.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын код **БНА-2022/68/НА-СТА-ТШЗ**



Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Март, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч У.Сүхбаатар нар зурж байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Заг сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу нийгмийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилд 30 орон тоотой, нийт 284 сурагч суралцсанаас насан туршийн боловсролоор 9, бага бүлэгт 176, дунд бүлэгт 99 суралцагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна. Тайлант онд нийт 541,847.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь 2021 онд боловсруулсан “Төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 625,731.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,257.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,380.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 4,781.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 121.842.6 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	<i>/мянган төгрөгөөр/</i>		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	118,999.3	68,037.0	(50,962.3)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	19,950.0	61.8	(19,888.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	99,049.3	67,975.2	(31,074.1)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,117,418.6	1,046,538.3	(70,880.3)
Үндсэн хөрөнгө	1,313,989.8	1,313,415.1	(574.7)
Хуримтлагдсан элэгдэл	(196,571.2)	(266,876.8)	(70,305.6)
Нийт хөрөнгө	1,236,417.9	1,114,575.3	(121,842.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,236,417.9	1,114,575.3	(121,842.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,236,417.9	1,114,575.3	(121,842.6)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 61.8 мянган төгрөг болж 19,888.2 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгөнд 19,950.0 мөнгөн төгрөгийн тавилга тоног төхөөрөмж нэмэгдэж, санхүүгийн тайлангаар залруулсан 61.8 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.



Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 67,975.2 мянган төгрөг болж 31074.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 37,542.6 мянга, сумын Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй олгосон 100.0 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн бөгөөд, байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Тусгай зориулалтын эд хөрөнгө актлах тухай” 101 дугаартай тушаалаар 32,587.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, үйл ажиллагаанд 36,129.5 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,313,415.1 мянган төгрөг болж 574.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 400.0 мянган төгрөгийн ном, өмнөх оны авлага 19,950.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 54 дүгээр тогтоол, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/135 дугаартай албан бичиг, захирлын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тушаалыг үндэслэн иргэн Д.Мөнхбаяраас үнэ төлбөргүй 1,329.2 мянган төгрөгийн өртөг бүхий чулуун барилгыг хүлээн авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн бөгөөд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор 21,767.9 мянган төгрөгийн өртөг бүхий гал тогооны барилга, 486.0 мянган төгрөгийн өртөг бүхий 243м² газрыг данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,114,575.3 мянган төгрөг болж 121,842.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 121,842.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 606,397.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 16,838.8 мянган төгрөгөөр бууруулж 516,838.8 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 3 удаа өөрчлөлт хийж 2021 оны 12 дугаар сард 541,847.4 мянган төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 81840.4 мянган төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгээс 459007.0 мянган төгрөг нийт 541847.4 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 77,495.9 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 459,007.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 514,787.9 мянган төгрөгийг зарцуулж 21,714.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 514,787.9 мянган төгрөг буюу 95 хувьтай байгаа нь цалин хөлс 7,750.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,058.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,344.8 мянга, хангамж бараа материалын Аудитын код **БНА-2022/68/НА-СТА-ТШЗ**

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

зардал 243.8 мянга, норматив зардал 7,057.1 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн БСУГазар буюу дээд шатны төсвийн захирагчаас багш нарын 5 жилийн тэтгэмж буюу тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 32,625.6 мянган төгрөг, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлт 10,000.0 мянган төгрөгийн авлага, түрээсийн номны үнэ 674.0 мянган төгрөг нийт 43,299.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 32,508.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 10,674.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 38 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 683,107.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 57,376.0 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бусад урсгал шилжүүлгийн зардлууд нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагчийн 2021.12.17-ны өдрийн 19-01/10 дугаартай “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагыг Сургуулийн захирал Б.Мартад хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд 579,802.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 516,591.1 мянган төгрөгийн 136 мэдээллийг хугацаанд нь, 63,211.2 мянган төгрөгийн 13 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	34	2	
5	Тухай бүр	8	96	86	10	
	Нийт	27	151	136	13	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

3.9.2 ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Тайлант онд 541,847.4 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 514,787.9 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал болох 35,795.0 мянган төгрөгөөс 3,579.5 мянган төгрөг хэмнэхээс 7,300.9 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 81,840.4 мянган төгрөгөөр баталж 76,495.6 мянган төгрөгийг зарцуулж нийт 16,368.1 мянган төгрөг хэмнэхээс 11,023.3 мянган төгрөгийг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

3.9.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тайлант онд аудитаар нийт 38,854.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,000.0 төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 9,950.0 мянган

Аудитын код **БНА-2022/68/НА-СТА-ТШЗ**



Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

төгрөгийн 2 зөвлөмж өгч 12,608.0 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулга хийсэн бөгөөд хэрэгжилтийг Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021.06.15-ны өдрийн 21 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Тус сургуулийн нярваар ажиллаж байсан П.Жаргалсайханыг Заг сумын сургуулийн захирал Ө.Мартын 2018.09.28-ны өдрийн 42 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөнд иргэн П.Жаргалсайхан хуулийн байгууллагад хандаж, Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 03-р сарын 10-ны өдрийн 131/ШШ2020/00311 тоот захирамжаар 2018.09.28-2019.11.01-ний өдөр хүртэлх хугацааны цалин, НДШ 6,948.2 төгрөгийг олгохоор тогтоосныг 2020 оны 4 сард 6,165.2 төгрөг, 12-р сард 130.9 төгрөг нийт 6,296.1 төгрөгийг тус байгууллагын 2020 оны цалингийн зардлаас олгосныг сургуулийн захирал Ө.Мартаар төлүүлэх албан шаардлага хүргүүлсэнийг хэрэгжүүлээгүй байна.

Мөн аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагчийн 2021.12.17-ны өдрийн 19-01/10 дугаартай “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагыг Сургуулийн захирал Б.Мартад хүргүүлсэн байна. Албан шаардлагын хэрэгжилтийг 2022.06.30-ны дотор ирүүлэхийг заасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74,296.3 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 61.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 74,234.5 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Байгууллагын хоорондын тооцоогоор НДШ-ийн авлага 61.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хууль 17 дугаар зүйл 17.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Оршин байх", "Үнэн зөв байдал, үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд Нийгмийн даатгалын хэлтсээс авах авлагаар 61.8 мянган төгрөгийг тусгуулж тайланг залруулав.

4.2 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1. Тус байгууллага нь 2021 онд 579,802.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 516,591.1 мянган төгрөгийн 136 мэдээллийг хугацаанд нь, 63,211.2 мянган төгрөгийн 13 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

2. Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 81,840.4 мянган төгрөгөөр баталж 76,495.6 мянган төгрөгийг зарцуулж нийт 16,368.1 мянган төгрөг хэмнэхээс 11,023.3 мянган төгрөгийг хэмнээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид байгууллагын удирдлага төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль	3	74,296.3	1	61.8					2	74,234.5

_____оОо_____

